



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны 01 сарын 03 өдөр

АКТ
Дугаар 03

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянговь сумын соёлын төвийн барилгын гүйцэтгэгч болох ЭЙ АР БИ СИ ХХК-д 10.0 сая төгрөгийн зээлийг "Баянговь сумын соёлын төвийн гүйцэтгэлтэй холбоотой санал солилцсон хурал"-аар Сум хөгжүүлэх сангаас олгохоор шийдвэрлэж олгосон. Тус зээлийн гэрээг Засаг дарга, Соёлын төвийн эрхлэгч, ЭЙ АР БИ СИ ХХК-тай гурвалсан гэрээ байгуулсан ба тус гэрээнд зээлийн хүүг сумын соёлын төв бүрэн хариуцан төлөхөөр гэрээнд тусгаж өгсөн. Зээлийн гэрээний хугацаа 2017.06.01-д дууссан ч төлбөр огт төлөгдөөгүй байна.

Дээрх зөрчил нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.4-д "Энэ журмын 3.3.3-т заасан зөвлөл иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн төсөл мөн журмын 4.3-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг хянах бөгөөд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар зохих шийдвэрийг гаргана.", 3.5.2-д Сумын засаг дарга нь "энэ журамд заасны дагуу зээл олгох шийдвэр гаргах;", 4.7-д "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө.", Төсвийн тухай хуулийн 6.4.5-д "төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016

2517033

оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан"... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зориулалт бусаар олгосон 10.0 сая төгрөгийн үндсэн зээл, 275000 төгрөгийн хүүгийн төлбөр нийт 10275000 /Арван сая хоёр зуун далан таван мянган/ төгрөгийг ЭЙ АР БИ СИ ХХК-иар төлүүлж Баянхонгор аймгийн Баянговь сумын Төрийн сан дахь Сум хөгжүүлэх сангийн 100030855401 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянговь сумын Засаг дарга Б.Эрдэнэбилэг, нягтлан бодогч Э.Пүрэвжаргал нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР
6-17143544
БЧ041067 9007423

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГА
 Б.ЭРДЭНЭБИЛЭГ
НЯГТЛАН БОДОГЧ
 Э.ПҮРЭВЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ
Дугаар 11

2018 оны 01 сарын 23 өдөр

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 2017.07.27-д сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнууд болох С.Энхцэцэг, О.Амаржаргал нарт тус бүр 300.0 мянган төгрөг олгосон.
2. Тус зардлаас хэмнэгдэж үлдсэн 600.0 мянган төгрөгийг нэр бүхий 6 ажилтныг тус бүр 100.0 мянган төгрөгөөр шагнаж зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтыг, Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан"... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

E:\Usukhuu\STA-2017\2.ИББЦГХ3\4.tailagnal\Aкт ИББЦГХ3.docx

2517049

3. Зориулалт бусаар олгосон 1200000 /Нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

4. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Г.Оюун-Эрдэнэ, нягтлан бодогч С.Мөнхбаатар нарт хариуцуулав.

АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР


ТОГТООСОН:

6417143544
E-DA0067 9007423

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

ИХ БОГДЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
Г. ОЮУН-ЭРДЭНЭ

НЯГТЛАН БОДОГЧ 
С.МӨНХБААТАР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 12

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад цалингийн тооцооллыг алдаатай гүйцэтгэснээс нэр бүхий 13 ажилтнаас 92397 төгрөгийн ХХОАТ-ыг дутуу тооцон суутгасан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26.1.2-д “энэ хуулийн 11.1.1-д заасан албан татварыг сар бүрийн эцэст ногдуулж, мөн хуулийн 24.1-д заасан хөнгөлөлтийг хасч, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан”... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**



1. Ажиллагсдаас дутуу суутгасан ХХОАТ болох 92397 /Ерэн хоёр мянга гурван зуун ерэн долоон/ төгрөгийг холбогдох хүмүүсээс суутган Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

E:\Usukhuu\STA-2017\2.ИББЦГХЗ\4.tailagnal\Aкт ИББЦГХЗ.docx

2517051

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга Г.Оюун-Эрдэнэ, нягтлан бодогч С.Мөнхбаатар нарт хариуцуулав.

АКТЫГ
ТОГТООСОН:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР
5417143544
5030067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:
ИХ БОГДЫН БАЙГАЛИЙН
ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
 Г.ОЮУН-ЭРДЭНЭ
НЯГТЛАН БОДОГЧ 
С.МӨНХБААТАР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 15

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад дундын фондын дансруу ажилчдын цалингаас суутгасан суутгалыг шилжүүлэхдээ 22000 төгрөг цалингийн зардлаас илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан "бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү шилжүүлсэн 22000 /Хорин хоёр мянган/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.


E:\Usukhuu\STA-2017\1.Tatwariin heltes\4.tailagnal\Akt Tatvar.docx


2517057

217

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Татварын хэлтсийн дарга С.Рэнцэндагва, нягтлан бодогч Д.Бат-Орших нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:
АУДИТОР  Ж.ӨСӨХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
 ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА
С.РЭНЦЭНДАГВА
НЯГТЛАН БОДОГЧ
Д.БАТ-ОРШИХ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 08 өдөр

Дугаар _____

Нөмгөн _____

Г Төлбөр барагдуулах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 2017.03.06-д сахилгын шийтгэл ногдуулсан ажилтнууд болох Ж.Олон, Э.Баасанбат нарт тус бүр 270.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудит-орын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан"... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:


1. Хууль, тогтоомж зөрчиж олгосон 540000 (Таван зуун дөчин мянган/ төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

E:\Usukhuu\STA-2017\5.Баянвоо сургууль\4.Tailagnal\Akt .docx

2517091

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Энхзаяа, нягтлан бодогч Л.Алимаа нарт хариуцуулав

АКТЫГ



ЗӨВШӨӨРСӨН:

БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ

P. Enkhzaya
П.ЭНХЗАЯА

НЯГТЛАН БОДОГЧ

L. Alima
Л.АЛИМАА

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-г зөвхөн "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвхөн дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

E:\Usukhuu\STA-2017\5.Баянновоо сургууль\4.Tailagnal\Akt .docx